

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2026/117/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.Open.audit.mn
Архангай аймаг
2026 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа

Утас: 7033-3141

Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Д.Нэргүйбаатар

Утас: 7033-2860

Цахим хаяг: Nerguibaatar@audit.gov.mn

Аудитор А.Пүрэвцэцэг

Утас: 99746363

Цахим хаяг: Purevtsetsega@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2026.02.13 № 34

танай _____-ны № _____-т

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
ГАЗРЫН ДАРГА Х.ГАНХУЯГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Худалдан авах ажиллагааны газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудал

Тайлангийн жилд 341,561.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, гүйцэтгэлээр 261,183.9 мянган төгрөгийг зарцуулж 80,378.0 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 үндсэн зорилтын хүрээнд 25 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 90.8 хувьтай байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
35	БАРАА МАТЕРИАЛ	200,000.00	1,460,000.00
354	Хангамжийн материал	200,000.00	1,460,000.00
3541	Бичиг хэргийн материал		480,000.00
3542	Аж ахуйн материал	200,000.00	980,000.00
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	200,000.00	1,460,000.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	28,238,353.29	27,526,431.14
392	Биет хөрөнгө	26,822,103.29	26,440,181.14
39203	Авто-тээврийн хэрэгсэл		19,800,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл		-19,800,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	24,587,803.11	31,001,738.11
39206	Хуримтлагдсан элэгдэл	-7,609,933.15	-12,701,206.93
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	12,126,649.80	12,430,399.80
39208	Хуримтлагдсан элэгдэл	-2,282,416.47	-4,290,749.84
393	Биет бус хөрөнгө	1,416,250.00	1,086,250.00
39301	Програм хангамж	1,650,000.00	1,650,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-233,750.00	-563,750.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	28,238,353.29	27,526,431.14
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	28,438,353.29	28,986,431.14
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		1,120,000.00
413	Өглөг		1,120,000.00
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг		1,120,000.00
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР		1,120,000.00
51	Засгийн газрын хувь оролцоо	28,438,353.29	27,866,431.14
512	Хуримтлагдсан үр дүн	28,438,353.29	27,866,431.14
5121	Өмнөх үеийн үр дүн	28,438,353.29	28,438,353.29
5122	Тайлант үеийн үр дүн		-571,922.15
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	28,438,353.29	27,866,431.14
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	28,438,353.29	28,986,431.14

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	308,872,700.00	338,201,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,000,000.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,000,000.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	303,872,700.00	338,201,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	303,872,700.00	338,201,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,945,757.21	8,208,854.35
120	Нийтлэг татварын бус орлого	9,945,757.21	8,208,854.35
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,200,000.00	3,360,000.00
120041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,200,000.00	3,360,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	3,745,757.21	4,848,854.35
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	318,818,457.21	346,410,754.35
21	УРСГАЛ ЗАРДАЛ	290,380,103.92	346,982,676.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	195,262,792.58	227,443,630.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	148,620,975.41	186,506,567.89

210101	Үндсэн цалин	113,869,982.91	97,275,879.02
210102	Нэмэгдэл	26,764,192.50	67,714,676.53
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,822,000.00	10,711,032.09
210104	Урамшуулал	4,164,800.00	10,804,980.25
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,296,078.25	22,288,255.81
210201	Тэтгэврийн даатгал	25,889,741.55	15,874,357.20
210202	Тэтгэмжийн даатгал	682,228.43	1,867,571.43
210203	ҮОМШӨ-ний даатгал	341,114.21	933,785.69
210204	Ажилгүйдлийн даатгал	254,261.21	722,508.28
210205	Эрүүл мэндийн даатгал	1,128,732.85	2,890,033.21
2104	Хангамж, бараа материалын зардал	7,803,935.00	5,724,630.00
210401	Бичиг хэрэг	4,432,485.00	2,961,350.00
210402	Тээвэр, шатахуун	2,300,000.00	1,200,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,071,450.00	1,563,280.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		1,646,500.00
210604	Урсгал засвар		1,646,500.00
2107	Томилолт, зочны зардал	3,768,000.00	2,090,000.00
210702	Дотоод албан томилолт	3,768,000.00	2,090,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,641,400.00	255,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,641,400.00	225,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		30,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,132,403.92	8,932,676.50
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	2,132,403.92	8,932,676.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	95,117,311.34	119,539,046.30
2132	Бусад урсгал шилжүүлэг	44,497,250.00	39,161,014.78
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20,373,500.00	38,661,014.78
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	20,595,000.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,528,750.00	500,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	50,620,061.34	80,378,031.52
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	50,600,061.34	80,378,031.52
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	20,000.00	
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	290,380,103.92	346,982,676.50
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	28,438,353.29	-571,922.15
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	28,438,353.29	-571,922.15

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/ төгрөгөөр /

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	315,072,700.00	341,561,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,200,000.00	3,360,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	6,200,000.00	3,360,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,200,000.00	3,360,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,200,000.00	3,360,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	308,872,700.00	338,201,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,000,000.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,000,000.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	303,872,700.00	338,201,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	303,872,700.00	338,201,900.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	288,447,700.00	338,190,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	288,447,700.00	338,190,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	192,910,388.66	218,650,953.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	157,802,655.10	186,506,567.89
210101	Үндсэн цалин	84,351,650.24	97,275,879.02
210102	Нэмэгдэл	55,337,254.86	67,714,676.53

Архангай аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,726,000.00	10,711,032.09
210104	Урамшуулал	10,387,750.00	10,804,980.25
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,694,398.56	22,288,255.81
210201	Тэтгэврийн даатгал	13,413,225.69	15,874,357.20
210202	Тэтгэмжийн даатгал	1,487,538.78	1,867,571.43
210203	ҮОМШӨ-ний даатгал	743,769.37	933,785.69
210204	Ажилгүйдлийн даатгал	569,184.22	722,508.28
210205	Эрүүл мэндийн даатгал	2,480,680.50	2,890,033.21
2104	Хангамж, бараа материалын зардал	8,003,935.00	5,709,630.00
210401	Бичиг хэрэг	4,632,485.00	2,129,350.00
210402	Тээвэр, шатахуун	2,300,000.00	1,200,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,071,450.00	1,563,280.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		817,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		2,426,500.00
210604	Урсгал засвар		2,426,500.00
2107	Томилолт, зочны зардал	3,768,000.00	970,000.00
210702	Дотоод албан томилолт	3,768,000.00	970,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,641,400.00	750,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,641,400.00	720,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		30,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	95,537,311.34	119,539,046.30
2132	Бусад урсгал шилжүүлэг	44,917,250.00	39,161,014.78
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20,373,500.00	38,661,014.78
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	20,595,000.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,948,750.00	500,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	50,620,061.34	80,378,031.52
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	50,600,061.34	80,378,031.52
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	20,000.00	
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	26,625,000.00	3,371,900.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	26,625,000.00	3,371,900.00
	Дотоод эх үүсвэрээр	26,625,000.00	3,371,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	26,625,000.00	3,371,900.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-26,625,000.00	-3,371,900.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)		
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
1	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			28,438,353.29	28,438,353.29
7	Тайлант үеийн үр дүн			-642,635.13	-642,635.13
10	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			28,438,353.29	28,438,353.29

17	Тайлант үеийн үр дүн			-571,922.15	-571,922.15
19	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			27,866,431.14	27,866,431.14

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
1	ТАТААС, САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО	344,386,100.00	257,823,868.48	86,562,231.52	74.86
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	344,386,100.00	257,823,868.48	86,562,231.52	74.86
132001	Орон нутгийн төсвөөс	344,386,100.00	257,823,868.48	86,562,231.52	74.86
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	3,000,000.00	3,360,000.00	-360,000.00	112
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,000,000.00	3,360,000.00	-360,000.00	112
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	347,386,100.00	261,183,868.48	86,202,231.52	75.19
21	УРСГАЛ ЗАРДАЛ	347,386,100.00	261,183,868.48	86,202,231.52	75.19
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	299,768,700.00	222,022,853.70	77,745,846.30	74.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	238,745,200.00	186,506,567.89	52,238,632.11	78.12
210101	Үндсэн цалин	108,739,000.00	97,275,879.02	11,463,120.98	89.46
210102	Нэмэгдэл	96,816,000.00	67,714,676.53	29,101,323.47	69.94
210103	Унаа хоолны хөнгөлөлт	18,190,200.00	10,711,032.09	7,479,167.91	58.88
210104	Урамшуулал	15,000,000.00	10,804,980.25	4,195,019.75	72.03
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,731,400.00	22,288,255.81	8,443,144.19	72.53
210201	Тэтгэврийн даатгал	20,897,800.00	15,874,357.20	5,023,442.80	75.96
210202	Тэтгэмжийн даатгал	2,458,400.00	1,867,571.43	590,828.57	75.97
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,229,200.00	933,785.69	295,414.31	75.97
210204	Ажилгүйдлийн даатгал	1,229,200.00	722,508.28	506,691.72	58.78
210205	Эрүүл мэндийн даатгал	4,916,800.00	2,890,033.21	2,026,766.79	58.78
2104	Хангамж, бараа материалын зардал	12,592,100.00	5,709,630.00	6,882,470.00	45.34
210401	Бичиг хэрэг	5,792,100.00	2,129,350.00	3,662,750.00	36.76
210402	Тээвэр, шатахуун	1,800,000.00	1,200,000.00	600,000.00	66.67
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,500,000.00	1,563,280.00	936,720.00	62.53
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,500,000.00	817,000.00	1,683,000.00	32.68
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,000,000.00	5,798,400.00	5,201,600.00	52.71
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,000,000.00	3,371,900.00	1,628,100.00	67.44
210604	Урсгал засвар	6,000,000.00	2,426,500.00	3,573,500.00	40.44
2107	Томилолт, зочны зардал	4,800,000.00	970,000.00	3,830,000.00	20.21
210702	Дотоод албан томилолт	4,800,000.00	970,000.00	3,830,000.00	20.21
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,900,000.00	750,000.00	1,150,000.00	39.47
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,400,000.00	720,000.00	680,000.00	51.43
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	500,000.00	30,000.00	470,000.00	6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	47,617,400.00	39,161,014.78	8,456,385.22	82.24
2132	Бусад урсгал шилжүүлэг	47,617,400.00	39,161,014.78	8,456,385.22	82.24
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	6,147,000.00		6,147,000.00	
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	38,670,400.00	38,661,014.78	9,385.22	99.98
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,800,000.00	500,000.00	2,300,000.00	17.86
2	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	347,386,100.00	261,183,868.48	86,202,231.52	75.19
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		100
5	АЖИЛЛАГСАДЫН ТОО	6	5	1	83.33
6	Удирдах ажилтан	1	1		100
7	Гүйцэтгэх ажилтан	5	4	1	80

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа илрээгүй, нийт 1,137.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Зөрчлийг арилгуулах 1 төлбөрийн акт, 2 албан шаардлага хүргүүллээ.

Аудитаар залруулагдаагүй 3 зөрчилтэй асуудлын материаллаг алдаа зөрчил нь 1,137.0 мянган төгрөг бөгөөд гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 2,412.6 мянган төгрөгөөс их байгаа тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

3.1 Төлбөрийн акт

3.1. Тайлант онд албан хаагчдад илүү цаг ажилласан нотлох баримт тушаалгүйгээр илүү цаг тооцон 1,137,088 төгрөгийг олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журмын "Төрийн албан хаагч энэ журмын хавсралтаар баталсан "Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас"-ны дагуу илүү цагаар..... ажилласан үндэслэл, гүйцэтгэсэн ажлын гол агуулга, нэмэгдүүлсэн цалин хөлсний тооцоог нэгжийн даргаар хянуулж баталгаажуулсны үндсэн дээр байгууллагын дарга зөвшөөрөл олгосны дараа санхүүд хүргүүлнэ" Нягтлагн бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Орон нутгийн төсвийн орлогын дансанд төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

3.2 Албан шаардлага

3.2.1 Аймгийн Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн А/645 дугаар захирамжаар байгууллагын бүтэц, орон тоог "газрын дарга-1, ахлах мэргэжилтэн-1, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн-1, дотоод хяналт шалгалтын мэргэжилтэн-1, хуулийн мэргэжилтэн-1, мэдээллийн технологи хариуцсан мэргэжилтэн-1, нягтлан бодогч, бичиг хэргийн ажилтан-1 нийт 7 орон тоотой баталсан байна. Батлагдсан бүтэц, орон тоонд тусгагдаагүй ажлыг хавсран гүйцэтгүүлж, нэмэгдэл цалин олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д -төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"; 16 дугаар зүйлийн 16.5.3-т "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан бүтэц орон тоонд багтаан ажиллах албан шаардлага хүргүүлэв

3.2.2 Үлдэх өртөггүй, элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн авто тээврийн хэрэгслийн дансанд 1 ширхэг 19,800,000 төгрөг, машин тоног төхөөрөмжийн дансанд 8 ширхэг 7,114,803.11 төгрөг, тавилга аж ахуйн эд хогшил дансанд 11 ширхэг 2,126,649.8 төгрөг, нийт 20 ширхэг 29,041,452.91 төргийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна.

Энэ нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.2-д "Эрх бүхий байгууллагын шийдвэрээр акталж, данснаас хасахаар шийдвэрлэж, зөвшөөрөл авсан боловч ашиглалтын шаардлага хангаж байгаа, дахин ашиглах боломжтой хөрөнгийн үнийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай зөвшилцөн тогтоож, дахин данс бүртгэлд тусгана", 2022 оны 65 дугаар тогтоолоор баталсан "Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ын 2.2.2-т "Зөвлөл нь төрийн өмчийг үрэгдүүлэх, үнэгүйдүүлэх, чанар байдлыг доройтуулах, эвдэж гэмтэх зэрэг аливаа эрсдэлээс урьдчилсан сэргийлэх, эзэмшилт, хадгалалт хамгаалалтыг сайжруулах, бүртгэл,

ашиглалтад хяналт тавих, үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авч ажиллах үндсэн үүрэгтэй” гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмч хамгаалах байнгын зөвлөлийг зохих ёсоор ажиллуулж зөрчлийг арилгуулах арга хэмжээг авч ажиллах албан шаардлага хүргүүлэв.

4. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага Д шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Батлагдсан бүтэц, орон тоонд тусгагдаагүй ажлыг хавсран гүйцэтгүүлж, нэмэгдэл цалин олгосон	1				1							
илүү цаг ажилласан нотлох баримт тушаалгүйгээр илүү цаг тооцон олгосон	1	1,137.0	1	1,137.0								
Тооллогын комисс, өмч хамгаалах байнгын зөвлөл хуулийн дагуу ажиллаагүй	1				1	0.0						
Дүн	3	4,446.3	1	1,338.3	2	0.0						